



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/436

Хэрлэн сум

Сонгон шалгаруулалтыг зохион
байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын 2 дугаар багт баригдаж буй жишиг хороололд худалдааны гудамж байгуулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч

Нарийн бичгийн дарга:

Хэрлэн сумын Нийгмийн бодлогын түшмэл

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрхзүйн хэлтсийн дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хэлтсийн дарга

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр эрхлэлтийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Худалдаа аж үйлдвэрлэлийн танхимын Хэнтий аймаг дахь салбарын тэргүүн


А.Боргил

Иргэдийн төлөөлөл (зөвшилцсөн)

2.

2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй сонгон шалгаруулалтыг цаг хугацаанд нь ил тод, нээлттэй зарлаж, шалгаруулахад хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ